

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/38/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Авирмэд Утас: 70453799, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.23 № УВА-2022/38/НА-СТА-ТЧЗ
танай _____-ны № _____-т

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Н.ӨЛЗИЙБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь аймгийн Засаг даргын 2021 оны А/104 дүгээр захирамжаар батлагдсан бүтэц орон тоог сар бүр 7-11 гэрээт ажилтнаар хэтрүүлэн ажилласан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтад “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

0200100038

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ



Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	5
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>19,281,483.76</u>	<u>42,417,299.76</u>
33	АВЛАГА	30,400.00	350,006.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	30,400.00	350,006.00
35	БАРАА МАТЕРИАЛ	19,251,083.76	42,067,293.76
351	Түүхий эд материал	10,000.00	10,000.00
35130	Эм боох материал	10,000.00	10,000.00
354	Хангамжийн материал	19,241,083.76	42,057,293.76
35410	Бичиг хэргийн материал	1,075,100.00	1,080,200.00
35420	Аж ахуйн материал	16,761,783.76	40,150,903.76
35430	Сэлбэг хэрэгсэл	1,120,400.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	583,190.00
35460	Хүнсний материал	40,800.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	243,000.00	243,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>48,528,458.25</u>	<u>99,474,679.89</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	48,528,458.25	99,474,679.89
392	Биет хөрөнгө	48,248,458.25	99,264,679.85
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30,000,000.00	30,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-8,437,500.00	-12,187,500.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	58,922,305.71	71,922,305.71
39206	Хуримтлагдсан элэгдэл	-51,151,763.65	-53,429,687.17
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,574,960.54	91,749,960.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26,253,444.35	-31,692,299.23
39217	Ном	1,593,900.00	2,901,900.00
393	Биет бус хөрөнгө	280,000.00	210,000.04
39301	Программ хангамж	720,000.00	720,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-440,000.00	-509,999.96
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>67,809,942.01</u>	<u>141,891,979.65</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,248,617.74</u>	<u>986,390.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,248,617.74	986,390.00
413	Өглөг	1,248,617.74	986,390.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	623,517.74	00.00
4136	Бусад өглөг	625,100.00	986,390.00
41361	Байгууллагад төлөх өглөг	625,100.00	906,390.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	80,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>66,561,324.27</u>	<u>140,905,589.65</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	66,561,324.27	140,905,589.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	64,701,245.00	64,701,245.00
51101	Өмч: - төрийн	64,701,245.00	64,701,245.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,860,079.27	76,204,344.65
51210	Өмнөх үеийн үр дүн	1,860,079.27	1,860,079.27
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	74,344,265.38
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>67,809,942.01</u>	<u>141,891,979.65</u>

2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	226,795,900.00	486,785,370.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	206,395,400.00	71,220,970.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	71,220,970.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	71,193,970.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	71,193,970.00
120009	Бусад орлого	00.00	27,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	206,395,400.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	162,946,900.00	00.00
123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	43,448,500.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	20,400,500.00	123,862,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	291,701,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,400,500.00	49,998,300.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,400,500.00	15,550,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	34,448,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	73,864,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	73,864,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	204,883,611.18	412,441,104.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	204,883,611.18	412,441,104.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	185,661,051.18	391,879,761.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	74,845,532.00	230,568,557.55
210101	Үндсэн цалин	73,808,370.00	166,825,858.35
210105	Гэрээт ажлын хөлс	1,037,162.00	63,742,699.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,472,785.00	31,253,637.55
210201	Тэтгэврийн даатгал	5,501,000.00	21,976,896.83
210202	Тэтгэмжийн даатгал	785,200.00	2,314,867.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	488,000.00	1,888,567.02
210204	Ажилгүйдлийн даатгал	577,600.00	460,414.78
210205	Эрүүл мэндийн даатгал	2,120,985.00	4,612,891.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,425,600.00	62,996,446.67
210301	Гэрэл, цахилгаан	00.00	847,031.67
210302	Түлш, халаалт	00.00	13,199,207.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	1,345,108.00
210304	Байрны түрээс	31,425,600.00	47,605,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,472,146.00	16,900,343.00
210401	Бичиг хэрэг	1,391,150.00	2,831,900.00

210402	Тээвэр, шатахуун	5,470,000.00	8,513,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	523,496.00	2,593,513.00
210404	Ном, хэвлэл	00.00	184,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	585,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,087,500.00	2,192,450.00
2105	Нормативт зардал	6,021,300.00	11,553,833.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	142,200.00	3,392,960.00
210502	Хоол, хүнс	5,879,100.00	8,160,873.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	639,000.00	1,120,400.00
210604	Урсгал засвар	639,000.00	1,120,400.00
2107	Томилолт, зочны зардал	652,000.00	332,000.00
210702	Дотоод албан томилолт	652,000.00	332,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,110,199.00	5,291,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,538,599.00	3,430,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	143,100.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	37,500.00	37,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	198,000.00	1,240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,022,489.18	31,862,793.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,775,500.00	12,719,515.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	323,600.00	7,606,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,923,389.18	11,536,778.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,222,560.00	20,561,343.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,222,560.00	3,605,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,180,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,560.00	3,605,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	16,956,343.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	21,912,288.82	74,344,265.38
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	21,912,288.82	74,344,265.38

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	421,987,300.00	415,591,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	395,016,800.00	27,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	27,000.00
120009	Бусад орлого	00.00	27,000.00
122	Тусламжийн орлого	78,734,400.00	00.00
122002	Хандив тусламж /гадаад/	78,734,400.00	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	316,282,400.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	316,282,400.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	26,970,500.00	415,564,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	291,701,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,970,500.00	49,998,300.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,400,500.00	15,550,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,570,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	34,448,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	73,864,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	73,864,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	421,987,300.00	415,591,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	421,987,300.00	415,591,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	386,838,268.56	395,030,056.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	164,960,607.56	231,511,681.29
210101	Үндсэн цалин	159,959,146.56	167,768,982.09
210105	Гэрээт ажлын хөлс	5,001,461.00	63,742,699.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,974,148.00	31,253,637.55
210201	Тэтгэврийн даатгал	14,562,848.00	21,993,618.13
210202	Тэтгэмжийн даатгал	1,602,800.00	2,315,002.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,282,300.00	1,852,001.71
210204	Ажилгүйдлийн даатгал	320,600.00	462,805.92
210205	Эрүүл мэндийн даатгал	3,205,600.00	4,630,209.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,327,555.00	62,996,446.67
210301	Гэрэл, цахилгаан	44,588.00	847,031.67
210302	Түлш, халаалт	3,299,802.00	13,199,207.00
210303	Цэвэр, бохир ус	131,965.00	1,345,108.00
210304	Байрны түрээс	62,851,200.00	47,605,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,582,076.00	18,652,467.00
210401	Бичиг хэрэг	2,987,400.00	2,413,900.00

210402	Тээвэр, шатахуун	8,300,000.00	8,513,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,987,576.00	2,593,513.00
210404	Ном, хэвлэл	275,000.00	298,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	149,800.00	585,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,882,300.00	4,248,574.00
2105	Нормативт зардал	5,592,000.00	12,032,519.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	682,200.00	3,392,960.00
210502	Хоол, хүнс	4,909,800.00	8,639,559.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,489,500.00	13,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	13,000,000.00
210604	Урсгал засвар	4,489,500.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	652,000.00	252,000.00
210702	Дотоод албан томилолт	652,000.00	252,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	89,372,182.00	5,341,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	88,800,582.00	3,480,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	143,100.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	37,500.00	37,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	198,000.00	1,240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,888,200.00	19,989,555.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,999,200.00	12,268,555.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	889,000.00	7,721,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,149,031.44	20,561,343.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,622,560.00	3,605,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,180,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,442,560.00	3,605,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,526,471.44	16,956,343.49
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	64,701,245.00	00.00	1,860,079.27	66,561,324.27
2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	64,701,245.00	00.00	1,860,079.27	66,561,324.27
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	64,701,245.00	00.00	1,860,079.27	66,561,324.27
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	74,344,265.38	74,344,265.38
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	64,701,245.00	00.00	76,204,344.65	140,905,589.65

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	373,812,200.00	348,888,148.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	373,812,200.00	348,888,148.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	373,312,200.00	348,438,148.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,512,400.00	231,511,681.29
210101	Үндсэн цалин	167,769,700.00	167,768,982.09
210105	Гэрээт ажлын хөлс	63,742,700.00	63,742,699.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,254,200.00	31,253,637.55
210201	Тэтгэврийн даатгал	21,993,700.00	21,993,618.13
210202	Тэтгэмжийн даатгал	2,315,100.00	2,315,002.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,852,100.00	1,852,001.71
210204	Ажилгүйдлийн даатгал	463,000.00	462,805.92
210205	Эрүүл мэндийн даатгал	4,630,300.00	4,630,209.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,110,300.00	62,996,446.67
210301	Гэрэл, цахилгаан	4,413,800.00	847,031.67
210302	Түлш, халаалт	31,583,500.00	13,199,207.00
210303	Цэвэр, бохир ус	837,000.00	1,345,108.00
210304	Байрны түрээс	45,276,000.00	47,605,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,353,200.00	10,068,743.00
210401	Бичиг хэрэг	2,900,000.00	1,393,500.00
210402	Тээвэр, шатахуун	6,200,000.00	3,363,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,149,800.00	2,093,513.00
210404	Ном, хэвлэл	300,000.00	298,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	612,500.00	585,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,190,900.00	2,335,250.00
2105	Нормативт зардал	5,425,600.00	5,408,990.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,568,400.00	1,563,900.00
210502	Хоол, хүнс	3,857,200.00	3,845,090.00
2107	Томилолт, зочны зардал	297,300.00	252,000.00
210702	Дотоод албан томилолт	297,300.00	252,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,070,000.00	821,750.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	210,000.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	37,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	120,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	208,000.00	200,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6289200.00	6124900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,511,000.00	5,499,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	778,200.00	625,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500000.00	450000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	450,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	450,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	373,812,200.00	348,888,148.51
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	291,701,900.00	285,891,701.84
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	291,701,900.00	285,891,701.84
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	82,110,300.00	62,996,446.67
132001	Орон нутгийн төсвөөс	82,110,300.00	62,996,446.67
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	19.00	19.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	49,746,908.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	49,746,908.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	46,591,908.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,583,724.00
210401	Бичиг хэрэг	1,020,400.00
210402	Тээвэр, шатахуун	5,150,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,913,324.00
2105	Нормативт зардал	6,623,529.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,829,060.00
210502	Хоол, хүнс	4,794,469.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,520,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,480,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,040,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13864655.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,768,655.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,096,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3155000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,155,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,155,000.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	49746908.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,746,908.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,550,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	34,196,908.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь Төрийн бодлогыг гэр бүлд суурилан хэрэгжүүлэх эрх зүй, тогтолцооны шинэчлэлд үнэт хувь нэмэр оруулж, гэр бүл, хүүхэд, залуучуудыг хамгаалах, хөгжүүлэх, төлөвшүүлэх үйлчилгээг сайжруулах замаар Монгол хүний хөгжлийг бэхжүүлэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 3.4 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 412.4 сая төгрөгийн 1 хувь буюу 4.1 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 3.3 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 74,082.0 мянган төгрөгөөр буюу 109.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	30.4	350.0	319.6
Урьдчилгаа			
Бараа материал	19,251.08	42,067.29	22,816.21
Үндсэн хөрөнгө	48,528.46	99,474.68	50,946.22
Нийт хөрөнгө	67,809.94	141,891.97	74,082.03
Өр төлбөр	1,248.62	986.39	-262.23
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	66,561.32	140,905.58	74,344.26
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	67,809.94	141,891.97	74,082.03

Бараа материалын дансны үлдэгдэл 42,067.1 мянган төгрөг болж 22,816.2 мянган төгрөгөөр өссөн нь Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлсэн хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төслийн хүрээнд бараа материал хүлээн авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 99,474.7 мянган төгрөг болж 50,946.2 мянган төгрөгөөр өссөн нь Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлсэн хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төслийн хүрээнд тавилга, тоног төхөөрөмж хүлээн авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансанд урсгал төсвийн худалдан авалтаар 13,000.0 мянга, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 49,483.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 986.4 мянган төгрөг болж 262.2 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны ажилчидтай холбогдсон өглөгийг барагдуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 140,905.6 мянган төгрөг болж 74,344.3 мянган төгрөгөөр өссөн нь нийт хөрөнгийн дүн өссөнөөс шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 259,989.5 мянган төгрөгөөр буюу 114.6 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 207,557.5 мянган төгрөгөөр буюу 101.3 хувиар өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 398,282.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 398,282.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 24,470.2 мянган төгрөгөөр бууруулж 373,812.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант 2021 онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 373,812.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 291,701.9 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 82,110.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 291,701.9 мянга, орон нутгийн төсвөөс 73,864.2 мянган төгрөг, нийт 365,566.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 348,888.1 мянган төгрөгийг зарцуулж 16,956.3 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 348,888.1 мянган төгрөг буюу 95.4 хувьтай байгаа нь зардлыг 16,956.3 мянган төгрөгөөр хэмнэж, орон нутгийн төсвөөс 8,246.0 мянган төгрөгийн санхүүжилт дутуу ирсэнтэй холбоотой байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн төсвөөс 15,550.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 34,448.3 мянга, бусад орлого 27.0 мянга, нийт 50,025.3 мянган төгрөгийн санхүүжилт авч 49,746.9 мянган төгрөгийг зарцуулж 278.3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх аудитаар илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 144, хугацаа хоцроож 5 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Цалин илүү тооцон олгосон, урьдчилгаа суутгаагүй 589.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосныг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Батлагдсан бүтэц орон тоог анхаарах.

4. Аудитын илрүүлэлт

Увс аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь өмнөх онд батлагдсан орон тоог хэтрүүлэн ажилласан зөрчилд “Орон нутгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл”-ийн аудитаар албан шаардлага өгсөн байна. Албан шаардлагын биелэлтийг хангуулахаар тус газарт 2 удаа хугацаатай албан бичиг хүргүүлсэн ч биелэлт хангагдаагүй тул Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт асуудлыг шийдвэрлүүлэхээр 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 480 дугаар албан бичгээр хандсан. Тус газраас 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/10 дугаар албан бичгээр цаашид орон тоог хэтрүүлэн ажиллах зөрчил гаргахгүй гэсэн хариуг ирүүлсэн байна.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь өмнөх оны зөрчлөө арилгаагүй, давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэж заасныг үндэслэн хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх үндэслэл үүссэн боловч 2022 оны 02 дугаар сард байгууллагын удирдлага өөрчлөгдсөн байна. Түүнчлэн тус газар нь 2022 оноос босоо тогтолцоотой болсон байна.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь аймгийн Засаг даргын 2021 оны А/104 дүгээр захирамжаар батлагдсан бүтэц орон тоог сар бүр 7-11 гэрээт ажилтан хэтрүүлэн ажиллуулж 56,310.4 мянган төгрөгийн цалингийн зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтад “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд үүссэн нөхцөл байдлыг харгалзан батлагдсан бүтэц орон тоог хэтрүүлсэн зөрчилд дахин албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

5. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	1	56,310.4					1	56,310.4		
НИЙТ		1	56,310.4					1	56,310.4		

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

Handwritten signatures and a red square stamp are present over the signature lines. The stamp contains Mongolian text and a central emblem.

/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Б.АВИРМЭД/

2022 оны 02 сарын 18-ны өдөр